



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 156

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон 13 нэр төрлийн нийт 88,988,040.00 (наян найман сая есөн зуун наян найман мянга дөчин) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Багануурын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Ганбаатарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000475

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн  
156 дугаар тогтоолын хавсралт

"БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	
					Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	ДС-н хашаа	1988.10.10	144	531,840.00	531,840.00	0.00
2	Гар тайль 3.2 тн	2001.04.23	1	1,700,000.00	1,700,000.00	0.00
3	Кран жин 10 тн	2012.03.22	1	7,000,000.00	7,000,000.00	0.00
4	Тайль 3.2 тн цахилгаан	2009.04.16	1	850,000.00	850,000.00	0.00
5	Токарын станок	1994.01.01	1	240,000.00	240,000.00	0.00
6	Технологийн хамгаалалт К-3,5,6,7,8,9,10,11,	2007.03.31	8	22,935,000.00	22,935,000.00	0.00
7	Нэмэлт усны зарцуулалтын хэмжүүр /Контерляр/	2009.12.31	5	1,225,000.00	1,225,000.00	0.00
8	Дулааны тоолуур NFEM-005 /Буцах / ф500 ком	2009.12.31	1	8,822,000.00	8,822,000.00	0.00
9	Дулааны тоолуур DN250 ф700	2010.01.05	1	12,264,100.00	12,264,100.00	0.00
10	Дулааны тоолуур DN-150 ҮТ/	2009.12.31	1	8,960,050.00	8,960,050.00	0.00
11	Прес /ачаат бүлүүрт/	2007.01.31	1	6,500,000.00	6,500,000.00	0.00
12	Дулааны тоолуур DN-150	2009.12.31	1	8,960,050.00	8,960,050.00	0.00
13	Цахилгаан хөдөлгүүр 160 квт 1000 эр/мин К11	2011.05.02	1	9,000,000.00	9,000,000.00	0.00
				<b>88,988,040.00</b>	<b>88,988,040.00</b>	<b>0.00</b>
<b>Нийт дүн</b>				(наян найман сая есөн зуун наян найман мянга дөчин)		